

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
“ХОТЫН СОЁЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 10 дугаар сарын 25

Багануур дүүрэг

1. Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйн хандлага, харилцааны соёлыг төлөвшүүлэх чиглэлээр дотооддоо сургалт зохион байгуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээндээ чирэгдэлгүй түргэн шуурхай байх






10 дугаар сарын 15-ны өдөр ажлын байрны стрессээс урьдчилан сэргийлэх, эерэг хандлага, харилцааны соёлыг хэрхэн түгээн дэлгэрүүлэх, нийгэмдэх бидний оролцоо хэрхэн нөлөөлөх талаар чөлөөт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хөрөнгө оруулагчид, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шаардлагатай мэдээ, мэдээллийг өдөрт нь, судалгааны чиглэлийн мэдээ мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан шуурхай хүргэн ажилладаг.

Байгууллагын албан хаагчид Соёлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган соёлын талаарх иргэний үүргээ биелүүлэн ажиллаж байна.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл, урлагийн газраас бэлтгэсэн соён гэгээрүүлэх нөлөөллийн контент, нэвтрүүлэг, зурагт хуудсыг байгууллагын олон нийтийн сүлжээний цахим хуудас болон албан хаагчдын хувийн фейсбүүк хуудсаар дамжуулан сурталчлах, давалгаалуулах ажлыг зохион байгуулах

Нийслэлийн Соёл, урлагийн газар фейсбүүк хуудсанд тавигдсан “Хот” цуврал нэвтрүүлэг, “Үзвэр үйлчилгээний соёл”, “Соёлтой хотод хамтдаа амьдарцгаая”, “Урлагийн хот Улаанбаатар соёлтой болгоё”, ОУ-ын кино наамдын талаарх мэдээлэл ... г.м зэрэг мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо - 57

	<p>“УЛААНБААТАР” ОЛОН УЛСЫН ХЭД КИНО НААДАМ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ</p> <p>Дэлгэрэнгүй</p>
	<p>Олон улсын кино наадам</p> <p>Дэлгэрэнгүй</p>
	<p>Соёлтой болгоё</p> <p>Дэлгэрэнгүй</p>
	<p>Хот цуврал нэвтрүүлэг</p> <p>Дэлгэрэнгүй</p>
	<p>Оюутан залуучуудад зориулсан видео контентийн уралдаан</p> <p>Дэлгэрэнгүй</p>

3. Аяны хүрээнд шинээр ажил санаачлан олон нийтэд сурталчлах

Байгууллагын халуун дотно уур амьсгалыг бий болгох, нийгмийн сөрөг хандлагаас зайлсхийж эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сөрөг бодолгүй, стрессгүй, соёлтой нийгмийг хамтдаа бүтээцгээе" уриалгыг гарган байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтийг уриалж байна. Цахим хуудаснаас мэдээллийг уншсан тоо - 46



СӨРӨГ БОДОЛГҮЙ,
СТРЕССГҮЙ,
СОЁЛТОЙ НИЙГМИЙГ
ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭЕ.



ТАЙЛАН ГАРГАСАН:
МАРКЕТИНГ, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА,
ХОТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Ч.Баярцэцэг* Ч.БАЯРЦЭЦЭГ